

ХӨХНИЙ ХОРТ ХАВДАР БА УДАМШИЛ

Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх зэрэгтэй эмч, клиникийн профессор, эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч Д.Өнөржаргал

Монгол улсад хөхний хорт хавдар эмэгтэйчүүдийн хавдрын дунд дөрөвдугаар байранд ордог бөгөөд энэхүү хорт хавдар үүсэхэд удамшил нөлөөлдөг болно.



Барууны орнуудад хөхний хорт хавдрын тохиолдлын 10% нь удамшилтай холбоотой байдаг.



BRCA-1, BRCA-2 уг генүүд мутацитай бол дараах эрсдэл дагуулна.

BRCA1 Хөхний өмөнгийн эрсдэл – 60-85%, өндгөвчний өмөнгийн эрсдэл - 40-60%.

BRCA2 Хөхний өмөнгийн эрсдэл - 50-85%, өндгөвчний өмөнгийн эрсдэл - 10-30%.

Удамшил BRCA-1, BRCA-2 ба эрчүүд

BRCA 2 ген илэрсэн эрэгтэй хүн амьдралын туршид хөхний хорт хавдар үүсэх эрсдэл нь 6-8% байдаг бол илрээгүй эрчүүдэд энэ эрсдэл нь 0,1% тооцоолдог. Мөн түрүү булчирхайн өмөнгийн эрсдэл 4,7 дахин ихэссэн байдаг тул 40 наснаас хойш жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт (цусанд PSA) хамрагдах ёстой.

BRCA 1 ген эрэгтэй хүнд хавдрын эрсдэлгүй.

Удамшлын шалгуур:

- 1-р төрлийн гэр бүлийн гишүүнд (ээж, эгч, дүү, охин) хөхний хорт хавдар оношлогдсон тохиолдолд өөрт хавдар оношлогдох эрсдэл 2 дахин ихсэж
- Гэр бүлийн 2 гишүүнд (эхийн эсвэл эцгийн талаас) хөхний хорт хавдар оношлогдсон тохиолдолд эрсдэл 3 дахин их байна.
- Жишээлбэл, гэр бүлийн 2 гишүүн хөхний хорт хавдраар өвчилж 1 нь 50 доош насанд оношлогдсон тохиолдолд тэр өвчтөн 65 нас хүрэхэд хавдар үүсэх эрсдэл 25% байна.

Хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлэх

Хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлэхийн тулд хөхөө өөрөө шалгах нь маш чухал. Эмэгтэйчүүд биений юм дууссанаас хойш 2-3 хоногийн дараа шалгах нь зүйтэй. Учир нь энэ үед хөх зөөлөрч, хэвийн байдалдаа орсон байх тул шалгахад хялбар болон өвдөлт багатай байдаг. Цэвэршсэн эмэгтэйчүүдийн хувьд санахад амар, тодорхой нэг өдөр, эсвэл сарын эхний хоногийг сонгох нь зохистой.

Хөхөө өөрөө шалгах арга:

Хөхний хорт хавдар нь хөхний булчирхай дотор хатуу, бэрсүү шиг зүйл үүсдэг. Үүнийг өөрөө маш хялбар шалгаж болдог.

1. Биеэ бүсэлхий хүртэл нүцгэлээд гараа ташаандаа авч толинд харна. Ингэхдээ хөхний хэлбэр, хэмжээ, өнгийг сайтар ажиглангаа хөхөн дээр ямар нэгэн хонхорхой, овгор, ургацаг эсвэл арьсан дээр ямар нэгэн өөрчлөлт байгаа эсэхийг харна.
2. Толины өмнө зогссон хэвээр гараа дээш өргөн хөх ба суганы хонхор хоорондын зай буюу хөхний хэсэг, нөсөөтэй хэсэг, хөхний товч хавиар шалгах хэрэгтэй.
3. Хөхний толгойг эрхий ба долоовор хураагаар зөөлөн чимхэж, ямар нэг зүйл, шингэн ялгадас гарч байгаа эсэхийг үзнэ.
4. Хурууны өндгөөр хөхний толгойг тойруулан тойрог маягаар эсвэл шулуун шугамаар, эсвэл од маягаар төвөөс захруу гурван чиглэлийн аль нэгийг сонгож, иллэг хийж болно.
5. Хэвтээ байдлаар зүүн гараараа тохиогоороо нугалан дээш өргөнө. Баруун гарын хурууны өндгөөр зүүн талын хөхийг зөөлөн тэмтэрч үзнэ. Хэрэв та өрөөсөн хөхөө хангалттай шалгасан гэж үзвэл нөгөө талынхаа хөхийг дээрх байдлаар шалгана.

Хөхөндөө үзлэг хийхдээ дараах өөрчлөлт байгаа эсэхийг сайтар тодруулна.

- Янз бүрийн бэрсүү тэмтрэгдэх
- Хөхний арьс улайж барзайх
- Хөхний аль нэг хэсэгт хэлбэр нь өөрчлөгдөн арьс хонхойх
- Хөхнөөс цусархаг болон идээрхэг ялгадас гарах
- Хөхний товч татагдан цааш хонхойх зэрэг шинж тэмдэг илэрвэл мэргэжлийн эмчид хандах хэрэгтэй.

